



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/134

Мандалговь

“Даянгүн орд” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/108 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Мал үржлийн ажлын дэмжлэг тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Даянгүн орд” ХХК-тай 35,907,240 (гучин таван сая есөн зуун долоон мянга хоёр зуун дөч) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Мал үржлийн ажлын дэмжлэг тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Даянгүн орд” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Халиун)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060582